



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

Г Далайн захиргааны бүтэц, дүрэм,
орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, Далай ашиглах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Далайн захиргааны бүтцийг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
- 2.Далайн захиргааны орон тооны хязгаарыг 31 байхаар тогтоосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Далайн захиргааны бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн батлах тухай” 12 дугаар тушаал, 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Б/09 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ




080000090

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20¹³ оны 02 дугаар сарын 08-ны едрийн
A/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Далайн захиргааны бүтэц, зохион байгуулалт



Зам, тээврийн хөгжлийн сайдын
20.23 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
A/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Монгол Улсын Далайн захиргаа /цаашид "Далайн захиргаа" гэх-/ны орон тоо, бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам, эрх үүргийн зохицуулалтыг тодорхойлно.

1.2. Далайн захиргаа нь Монгол Улсын далайн болон усан замын тээврийн салбарын бодлого, хөтөлбөр, төслийг Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, дүрэм, журам, стандарт, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллага болно.

1.3. Далайн захиргаа нь далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллана.

1.4. Далайн захиргаа нь далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж, тайлagnana.

1.5. Далайн захиргаа нь билэгдэлтэй байх бөгөөд гадаад, дотоод албан бичгийн хэвлэмэл хуудас, тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг хэрэглэнэ.

1.6. Далайн захиргаа нь далайн салбарын Монгол Улсын олон улсын гэрээ, Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанаас олсон орлогоос далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан орлого, зарлагын төлөвлөгөөний дагуу санхүүжиж, улсын төсөвт орлого төвлөрүүлдэг төрийн байгууллага мөн.

Хоёр. Далайн захиргааны үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. Далайн захиргаа нь өөрийн үйл ажиллагаандаа Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, олон улсын далайн эрх зүйн талаарх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, олон улсын эрх бүхий байгууллагын зөвлөмж, заавар, гадаад улс орнуудтай далайн салбарт байгуулсан гэрээ, хэлэлцээр, УИХ, Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр, "Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам" болон бусад холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

2.2. Далайн захиргааны үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын хууль, тогтоомж, далайн салбарын олон улсын гэрээ, конвенцын хэм хэмжээнд нийцүүлэн хөлөг онгоц болон усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын үйл ажиллагаа явуулах, далайн болон усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, салбарын боловсон хүчинийг бэлтгэх, далайн тээвэр, боомт ашиглахтай холбогдсон эрх үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

Гурав. Далайн захиргааны бүтэц, зохион байгуулалт

3.1. Далайн захиргаа нь энэхүү дүрмийн 2.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, орон тоотой байна.

3.2. Далайн захиргааны орон тооны хязгаарыг тогтоох, удирдлагыг томилох, дүрмийг батлах асуудлыг далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

3.3. Далайн захиргааны дарга нь далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан орон тооны хязгаарт багтаан Далайн захиргааны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратегийг батална.

3.4. Далайн захиргааны дарга нь байгууллагын дотоод дүрэм, журмыг батлан мөрдүүлж ажиллана.

3.5. Далайн захиргаа нь үйл ажиллагаагаа дараах үндсэн салбар, чиглэлээр хэрэгжүүлнэ.
Үүнд:

3.5.1. Хөлөг онгоцны бүртгэл, хяналт

3.5.2. Далайн тээвэр, боомт ашиглалт, хуурай боомт

3.5.3. Усан замын тээврийн бүртгэл, хяналт

3.5.4. Салбарын боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах.

3.6. Далайн захиргааны дарга Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль, Усан замын тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль болон энэхүү дүрэм, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

3.7. Далайн захиргааны усан замын тээврийн улсын байцаагч, далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч нь олон улсын жишигт нийцсэн дүрэмт хувцастай байж болно. Хяналтын улсын байцаагч нь дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд дүрэмт хувцасны загвар, ялгах тэмдгийг далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Далайн захиргааны эрх, үүрэг

4.1. Далайн захиргаа нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Монгол Улс далбааны эзэн улсын хувьд ОУДБ-ын Эрх зүйн актыг хэрэгжүүлэх дүрмийн дагуу Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэх талаар эрх бүхий байгууллагаас баталсан далайн салбарын стратеги, бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах, энэ чиглэлийн мэдээллээр удирдлагыг хангах;

4.1.2. Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох байгууллагуудад тайлagnаж ажиллах;

4.1.3. Далайн салбарын чиглэлээр дотоод, гадаадын холбогдох байгууллагатай хамтарсан сургалт зохион байгуулах, салбарын боловсон хүчин бэлтгэх,



мэргэшүүлэх, мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, дадлагажуулах ажлыг хамтран зохион байгуулах;

4.1.4. Далайн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын гэрээ, конвенц, түүний нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох, соёрхон батлах хуулийн төсөл боловсруулах тухай саналыг далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавих;

4.1.5. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд үндэсний боловсон хүчнийг ажиллуулах асуудлыг зохион байгуулах;

4.1.6. Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.1.7. Олон улсын байгууллагаас гаргасан далайн болон усан замын тээврийн салбарын зөвлөмжийг үйл ажиллагаандаа удирдамж болгон ажиллах, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр цаг тухайд нь хангах;

4.1.8. Олон улсын байгууллагууд болон бусад улсын далайн салбарын холбогдох байгууллагуудтай бодлогын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үргээ хэрэгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллах;

4.1.9. Олон улсын далайн байгууллага (ОУДБ) болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулж буй хурал, зөвлөгөөн, семинарт оролцох, түүнээс гарах шийдвэрт санал боловсруулж тусгуулах асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.1.10. Хууль тогтоомжид нийцуулэн бүрэн эрхийнхээ хүрээнд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

4.1.11. Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр боловсруулах, ажилтныг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж ажилд авах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

4.1.12. Далайн болон усан замын тээврийн салбарт хөрөнгө оруулах нөхцөл боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

4.1.13. Далайн болон усан замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулах асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулан ажиллах;

4.1.14. Хариуцсан ажлын чиглэлээр шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэх зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаад, дотоодын шинжээч, мэргэжилтнийг томилон ажиллуулах, бусад ажилтныг гэрээний үндсэн дээр татан оролцуулах, тэдгээрт цалин, урамшуулалт олгох асуудлыг шийдвэрлэх;

4.1.15. Усан замын тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулах, шийдвэр гаргахад оролцох.

4.1.16. "Усан зам, далайн тээвэрчдийн өдөр"-ийг жил бүрийн 08 дугаар сарын 20-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.

4.2. Далайн захиргаа нь Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, цуцлах, далбааны эзэн улсын хяналт тавих чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.1. Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

4.2.2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журмын дагуу хөлөг онгоцонд хиймэл дагуулын холбооны дугаар, дуудлагын дугаар, бүртгэлийн түр, байнгын, нэг удаагийн аяллын болон дангаар түрээслэх гэрчилгээ олгох, сунгах, хүчингүй болгох, цуцлах;

4.2.3. Хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагчийг сонгон шалгаруулсны үндсэн дээр гэрээ байгуулан хамтран ажиллах;

4.2.4. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой маягт, гэрчилгээний загварыг олон улсын жишигт нийцүүлэн батлах;

4.2.5. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны тайлан, мэдээг сар, улирал, жилээр тухай бүр нэгтгэн боловсруулж, санал дүгнэлт гаргах, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;

4.2.6. Далбааны эзэн улсын нэрийн өмнөөс хөлөг онгоцонд техникийн үзлэг, шалгалт хийх, хяналт тавих, холбогдох гэрчилгээ олгох асуудлаар Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх;

4.2.7. Бүртгэлтэй хөлөг онгоцны зөрчил болон saatuulalтын тоог бууруулах арга хэмжээ авах, боомт болон эргийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах, удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангах;

4.2.8. Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч болон хянан шалгагчийг томилон ажиллуулах;

4.2.9. Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах, байршил тогтоох системийг нэвтрүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

4.2.10. Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ОУДБ-ын дэлхий нийтийн далайн тээврийн мэдээллийн нэгдсэн системд тухай бүр оруулж, тайлагнаж ажиллах;

4.2.11. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын гэрээ, конвенц, дотоод хууль тогтоомжид нийцүүлэн явуулахтай холбогдсон Захиргааны мэдэгдлийг оролцогч талуудад бичгээр хүргүүлэх арга хэмжээ авах, мэдээллээр хангаж ажиллах;

4.2.12. Хөлөг онгоцны багийн гишүүдийн чадамжийн гэрчилгээг баталгаажуулж, гэрчилгээ олгох.

4.2.13. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцон дээр ажиллах далайчны дэвтрийг олгох асуудлыг судалж, шийдвэрлэх;

4.3. Далайн захиргаа нь усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1. Усан замын тээврийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт санал өгөх, хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах, удирдлагыг мэдээллээр хангах;

4.3.2. Усан замын тээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох, усан замын тээврийн салбарт шинээр батлуулах шаардлагатай норм, норматив, стандартын төсөл боловсруулан усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

4.3.3. Усан замын тээврийн хэрэгслийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, шилжилт хөдөлгөөний тэмдэглэл хийх, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаар олгох, цуцлах, бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх;

4.3.4. Усан замын тээврийн хэрэгслийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нелөө үзүүлэх хүчин зүйлсийн зөвшөөрөгдхөх хэмжээний түвшин, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан байдалд техникийн хяналтын үзлэг хийж, усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тухай бүр тэмдэглэл хийх;

4.3.5. Усан замын тээврийн хэрэгслийн хувийн хэргийг олгох, хувийн хэрэг хөтлөлтийн байдалд хяналт тавих;

4.3.6. Усан замын тээврийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг тодорхойлох, төлөвлөгөө, төсөл боловсруулан хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллах;

4.3.7. Усан замын тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, семинар, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, усан замын тээврийн хэрэгсэл өмчлөг, зэмшигчид болон усан замын тээврийн хэрэгслийн жолооч нарыг хамруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

4.3.8. Усан замын тээврийн салбарын үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээний ажлын хөтөлбөр, төсөл боловсруулах чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах;

4.3.9. Сургалтын батлагдсан хөтөлбөрийн дагуу усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэдэг сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлгээ баталгаажуулалтын ажилтанг эрх бүхий байгууллагатай хамтран бэлтгэх, мэргэжлийн шалгалтын комисст орж ажиллах саналыг гаргах, усан замын тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн үнэмлэх олгох, мэдээллийн сан бүрдүүлэх;

4.3.10. Далайн болон усан замын тээврийн салбарын Мэргэжлийн зөвлөлийг байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.3.11. Усан замын тээврийн болон усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалд тавих хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх;

МОНГОЛ УЛСЫН

ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯAM

ЭХ ХУВЬ

Сайд Төрийн нарийн бичгийн
дэргүүцэлийн төслийн түвшнээс

4.3.12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг хангаагүй аж ахуй нэгж, иргэний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаарх саналыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

4.3.13. Усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу аж ахуйн нэгж, иргэдээс авч нэгтгэн усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

4.4. Далайн захиргаа нь далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.1. Далайн болон усан замын тээврийн салбарын бодлого, стратеги боловсруулах, хууль, тогтоомжийг боловсронгуй болгоход далайн тээвэр, логистик, боомт ашиглах чиглэлээр санал өгч, хэрэгжүүлэх;

4.4.2. Далайн тээвэр, логистикийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудыг оролцуулах, хамтарч ажиллах;

4.4.3. Засгийн газар хооронд далайн тээвэр, логистик, боомт ашиглах чиглэлээр байгуулагдсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгийг хэрэгжүүлж ажиллах;

4.4.4. Хөрш орнуудын болон гуравдагч орны далайн боомтуудыг ашиглах боломжийн талаар судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, шийдвэрлүүлэх;

4.4.5. Бусад орнуудын далайн боомтод Төлөөлөгчийн газар нээн ажиллуулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

4.4.6. Хөрш орнууд болон бусад далайд гарцтай орнуудаар дамжин далайд гарах боломжийг эрэлхийлэх, далайн боомтуудын судалгаанд үндэслэн тэдгээрийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах чиглэлээр боомтын байгууллагуудтай хамтран ажиллах;

4.4.7. Далайн тээвэр, логистикийн талаарх олон улсын стандартыг нутагшуулах чиглэлээр санал боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, олон нийтэд таниulan сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4.8. Далайн тээврийн үйл ажиллагааг эрхлэх чиглэлээр далайд гарцтай орнуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, төслийн нэгж байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;

4.4.9. Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хуурай боомтын асуудал хариуцсан нэгжийг далайн тээвэр, боомт ашиглалтын албаны эрхлэх асуудлын хүрээнд байгуулан ажиллуулах, бусад орны хуурай боомтын талаар судалгаа хийх, туршлага судлах, санал дүгнэлт боловсруулах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох ажлын хэсэгт орж ажиллах;

4.4.10. Хуурай боомтыг Монгол Улсад байгуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;



Тав. Далайн захиргааны санхүүжилт

5.1. Далайн захиргааны жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хянаж батална.

5.2. Далайн захиргаа нь Далай ашиглах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу явуулж буй үйл ажиллагааны орлогоос санхүүжнэ.

5.3. Үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвийг Далайн захиргааны үйл ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулна.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба далай ашиглалт, усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, эсхүл хүчингүй болгоно.

----оОо----

